

ТАНИЛЦУУЛГА

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 05 дугаар сарын 29-ний өдөр баталсан Хууль тогтоомжийн тухай хуулийг 2016 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс дагаж мөрдөхөөр байсныг хуулийн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах, хуульд заасан аргачлал, журмыг батлах зэргээр хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах үүднээс 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн Хууль тогтоомжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар хуулийг дагаж мөрдөх хугацааг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болгосон билээ.

Хууль тогтоомжийн тухай хууль нь хууль тогтоомжийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн төсөлд тавигдах шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, хууль тогтоомжийн төслийн болон хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх зэргээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох үйл явцыг хангахад ач холбогдолтой хууль болсон.

Энэ хугацаанд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас уг хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллалаа. Тухайлбал, хуульд заасан Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал, Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал, Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал, Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал, Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийх аргачлалуудыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан, түүнчлэн дээрх аргачлалын гарын авлагыг Хууль зүй, дотоод хэргийн яам Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах” төсөлтэй хамтран боловсруулж гаргасан, түүнчлэн мөн сургагч багшийг бэлтгэсэн, Хууль зүйн сайдын 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/221 дугаар тушаалаар хуульд заасан “Хууль тогтоомжийн сан бүрдүүлж, системчлэн ангилах журам”, “Хууль тогтоомжийн хувийн хэрэг бүрдүүлэх журам” баталсан, аргачлалуудыг хэрэглэх дадлага олгох сургалтыг УИХТГ, ЕТГ, ЗГХЭГ, бүх яамд, Улсын Их хурлаас байгуулагддаг байгууллагууд, Ерөнхий сайд, Шадар сайдын харьяа эрхлэх асуудлын хүрээний агентлаг зэрэг байгууллагуудын албан хаагчдад шат дараатайгаар зохион байгуулсан зэрэг ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

Засгийн газрын 2016 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдааны 54 дүгээр тэмдэглэлээр Хууль тогтоомжийн тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангагдсан эсэх талаар танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайдад даалгасны дагуу Засгийн газрын 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанд хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын талаар болон хуулийг хэрэгжүүлэхэд цаашид анхаарах асуудлын талаар танилцуулж, Засгийн газраас дараахь арга хэмжээ авахыг Хууль зүй дотоод хэргийн сайд болон Засгийн газрын гишүүдэд даалгасан юм. Үүнд:

1/Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг баталж, хуулийн төслийг яаралтай боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайдад;

2/Хууль тогтоомжийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд эрхлэх асуудлын хүрээндээ хуульд заасан аргачлалуудын дагуу судалгаа, үнэлгээ хийх чиг үүргийг хариуцах албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод тусгах, тэдгээрийг чадавхижуулж, хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд.

Засгийн газраас даалгасны дагуу, түүнчлэн хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах явцад практикт тулгарсан хүндрэл бэрхшээл, сургалтад хамрагдсан албан хаагчдын санал, хүсэлт зэргийг нэгтгэн дүгнэж хуулийг хэрэгжүүлэхэд тулгараад байгаа асуудлыг шийдвэрлэж, хуулийг нэг мөр хэрэгжүүлэх үүднээс Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлагыг үндэслэн хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлж, түүнд нийцүүлж хуулийн төслийг боловсруулав.

Хуулийн төсөлд дараахь харилцааг зохицуулсан. Үүнд:

1.Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2-12.1.6-д заасны дагуу ЗГ-ын тогтоолоор баталсан аргачлалд тусгасан эдгээр аргачлалын дагуу судалгаа, үнэлгээ хийх болон зардлыг тооцох шаардлагагүй хууль тогтоомжийн төслийн хүрээг тодорхойлсон.

2.Хуульд заасан аргачлалын дагуу хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийсэн, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээ хийсэнтэй холбогдуулан энэ талаар гарах дүгнэлт, зөвлөмжийг хуульд тусган, холбогдох материалыг /тайлан, дүгнэлт, зөвлөмж/ тухайн үе шатанд баримтжуулж хавсаргаж ирүүлэх асуудлыг зохицуулсан.

3.Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх, хууль тогтоомжийн үр дагаварын үнэлгээ хийх асуудлууд нь агуулгын хувьд давхардсанаас хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэхэд учир дутагдалтай байсан тул асуудлыг нэг мөр шийдвэрлэх үүднээс хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх асуудлыг хүчингүй болгохоор тусгалаа.

4.Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалснаас гадна хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр тухайн хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах шаардлагатай талаарх гарсан дүгнэлт, зөвлөмж нь хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төсөл боловсруулах үндэслэл болохоор байх тул энэ талаар холбогдох зохицуулалтыг тусгав.

5.Хуульд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээг хийх хугацаа тодорхойгүй тул хугацааг хуульчлах, эсхүл шаардлагатай үед үнэлгээ хийж байх зохицуулалтыг тусгаж өгөв.

6.Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар бүлэгт захиргааны хэм хэмжээний актын талаарх харилцааг тодорхой зохицуулсан тул Хууль тогтоомжийн тухай хуулиар уг харилцааг давхардуулан зохицуулах шаардлагагүй гэж үзэн хуулийн 48 дугаар зүйлийг хүчингүй болгохоор тусгалаа.

7.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл нь аливаа нэг зохицуулалтыг дуусгах үр дагавартай тул энэхүү хуулийн төслийг хуулийн төслийн төрөлд хамааруулан тусгав.

8.Хууль тогтоомжийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг хэл зүй, найруулгын тухайд ойлгомжтой, тодорхой болгох үүднээс найруулгын шинжтэй зарим өөрчлөлтүүдийг хийв.

Хууль тогтоомжийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч байсан дээрх асуудлуудыг шийдвэрлэх хэрэгцээ, шаардлагыг үндэслэн хуулийг нэг мөр хэрэгжүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх үүднээс Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ